

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 05 өдөр

Дугаар: 18

Улаанбаатар хот

Мөнгөн хөрөнгийн талаар шийдвэр  
гаргах эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 80 дугаар зүйлийн 80.2, 83 дугаар зүйлийн 83.8, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгө зохицуулах журам”-ын 3.2.6-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөрөнгө зохицуулах журамд заасан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулах, буцаан татах асуудлаар шийдвэр гаргах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д олгосугай.

2. Компанийн мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулах, буцаан татах шийдвэр гаргахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлж ажиллах, Хөрөнгө зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг харгалзан үзэхийг тус тус Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2023 оны 9 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ